



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 5/331

Улаанбаатар хот

Б.Нямдавааг ажлаас чөлөөлж, нэг удаагийн
буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271^{1.1.7}, 271^{1.1.10} дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан Гаалийн ерөнхий газрын харьяа Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Баярын Нямдавааг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Б.Нямдаваад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 29.847.500 /хорин есөн сая найман зуун дөчин долоон мянга таван зуун/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3.Ажлаас чөлөөлөгдөж байгаа Б.Нямдаваагийн гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авч, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар /Г.Баасандорж/-т тус тус даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ